



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 45/

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.3, 6.2.5, 6.4.3, 6.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 218,955.35 (хоёр зуун арван найман мянга есөн зуун тавин таван ам доллар гучин таван цент) ам.долларын балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин Сайд, Улаанбаатарын худалдаа эдийн засгийн төлөөлөгчийн газрын тэргүүн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж устгах, данснаас хасах, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000860



Төрийн өмчийн содлоогч зохих дуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 45/ дугаар тооллын хавсралт

Монгол Улсаас гадаад улсад суугаа элчин сайдын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж худалдах хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашинь марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэр лэсэн он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ төгрөг (ам.доллар)	Хуримтлагдсан элэгдэл (ам.доллар)	Үлдэх өртөг (ам.доллар)	Худалдах доод үнэ (ам.доллар)	Байршил
1	BMW-528i маркийн, CD GE 288 улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар WBAFS5100OC627826	2011	189000	50,365.90	50,365.90	-	1,000.00	Женев БТГазар
2	Мерседес бенз М1 маркийн, 639-2 улсын дугаартай, микроавтобус, арлын дугаар WDF63970313773861	2012	190000	37,611.38	37,611.38	-	1,000.00	Прага ЭСЯ
3	Вольскваген маркийн, 123CD4092 Улсын дугаартай, микроавтобус, арлын дугаар WV2ZZZ7HZCHO23522	2012	150000	50,716.06	50,716.06	-		Парис ЭСЯ
4	Мерседес бенз С180 маркийн, 01012 дугаартай, суудлын автомашин, арлын дугаар WDD2040461A258486	2008	137001	45,679.01	45,679.01	-	500.00	Берлин ЭСЯ
5	Honda Accord маркийн, 350 дугаартай, суудлын автомашин, арлын дугаар RKTCP36309F000041	2008	131652	34,583.00	34,583.00	-	500.00	Тайбэй УБХЭЗТГазар
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН					218,955.35	0.00	3,000.00	-
					218,955.35 (хоёр зуун арван найман мянга есөн зуун тавин таван ам доллар гучин таван цент)		3,000.00 (гурван мянга таван мянга ам доллар)	-